

**ӨМӨЗО-Ы ШИЛИЙН ГОЛ АЙМГИЙН СӨНИД БАРУУН ХОШУУНЫ
МОНГОЛ БАГА СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН БИЕЙН ТАМИРЫН
ХИЧЭЭЛД ХАНДАХ ХАНДЛАГЫН СУДАЛГАА**

*Э. Нарантунгалаг
Доктор (Ph. D.)*

*Монгол улсын боловсролын их сургууль
Биеийн тамирын сургууль*

erdenechuluun@msue.edu.mn

*Н. Хавар
Магистр оюутан*

*Монгол улсын боловсролын их сургууль
Биеийн тамирын сургууль*

erdenechuluun@msue.edu.mn

Хураангуй: Энэхүү илтгэлийн хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Сөнид баруун хошууны бага сургуулийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг судлан тодорхойлж, биеийн тамирын хичээлийн сургалтыг сайжруулах санал боловсруулахыг зорьсон болно. Шилийн гол аймгийн Сөнид баруун хошууны монгол бага сургуулийн 972 сурагчдаас сурвалж бичиг, анкет, онолын логик задлан шинжлэл, ярилцлагын аргыг тус тус ашиглан судалгаа авч, үр дүнд шинжилгээ дүгнэлт хийв. Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцсон сурагчдын 86 хувь нь биеийн тамирын хичээл нь бие махбодийг чийрэгжүүлэх, эрүүл байх нэг хүчин зүйл гэж үзжээ. Сурагчдын 25 хувь нь биеийн тамирын хичээлдээ тийм ч сэтгэл ханамжтай биш, 54%-хувь нь оролцох идэвх сул, 24 хувь нь хичээл явуулж буй арга хэлбэр, агуулга нь таалагдахгүй байгааг илэрхийлжээ. Биеийн тамирын хичээлийн багш нар, тухайн хичээлийн ач тусыг ойлгуулах, сурагчдын биеийн тамираар хичээллэх сонирхол идэвх оролцоог дэмжих тал дээр хангалтгүй ажиллаж байгааг анхааран үзэж цаашид биеийн тамирын хичээлийн агуулга арга зүйг сайжруулах, сургалт явагдах сургалтын тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна.

Түлхүүр үгс: бага ангийн сурагчид, хичээлд хандах хандлага, мэдлэг, сэтгэл хөдлөл, зан үйл

УДИРТГАЛ

Сэдвийн судлагдсан байдлын тойм, судлах эрэлт хэрэгцээ. Хүний хөгжлийг эрүүл мэнд, боловсрол, орлого гэсэн үзүүлэлтээр хэмжиж байгааг дэлхийн улс орнуудын хөгжлийн илтгэлээс харж болно. Өнөөгийн нийгмийн хурдацтай хөгжил, бүтээмжийн өсөлт нь эрүүл чийрэг бие бялдар, оюунлаг бүтээлч сэтгэлгээ, амьдралын зөв дадал хэвшил, аливаад хандах хандлагаас ихээхэн шалтгаалах болж байна. Багш сурагчдын

биеийн тамирын хандах өнөөгийн хандлага, эрүүл мэндийн боловсролын ач тус, үзүүлэх нөлөөг хүүхэд бүрийн сэтгэл зүйд суулгаж чадсанаар дээрх зорилтод хүрэх нэг алхам болох юм. Энэхүү зорилттой уялдан дунд болон бага сургуулийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг сайжруулж, тэдний биеийн тамираар хичээллэх хүсэл сонирхол, урам зориг сэдлийг дэмжиж, эрүүл мэндийн боловсрол олгох тогтолцоог сайжруулах нь боловсролын байгууллагын өмнө тулгамдаж буй чухал асуудал болж байна.

Хүүхдийн бие сэтгэцийн хөгжлийн хамгийн чухал цаг үе нь дунд болон бага сургуульд суралцаж байх үеэс эхлэл суурь нь тавигддаг. Ялангуяа бие бялдрын боловсрол эзэмших суурь үе бол бага, дунд сургуулиас эхлэх ёстой. Тэр тусмаа бага сургуулийн үеийн сургалтын үйл ажиллагаа түүний дотроос биеийн тамирын хичээл нь энэ насны хүүхдийн бие бялдар болон сэтгэцийн хөгжилд маш чухал нөлөөтэй болохыг олон судлаачид онцлон авч үзэж иржээ.(Жоу Дэנסон нар 2000) Биеийн тамирын хичээлд хандах хандлагын талаарх судалгаануудыг тоймлон авч үзэхэд ихэнх судалгаанууд ахлах ангийн сурагчид болон оюутны түүвэр дээр хийгдсэн байна. Тухайлбал, БНХАУ-ын Canan&Hulya(2005) зэрэг судлаачид өсвөр насны ахлах ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг судалж, хөвгүүдийг охидтой харьцуулахад биеийн тамирын хичээлд хандах хандлагын хувьд харьцангуй илүү байдаг. Мөн биеийн тамирын хичээлийн агуулга, заах арга зүй, багшийн зан харилцаа, сурагчдын өөртөө итгэх итгэл, хичээл чармайлт, сургалтын орчин, спортын тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж зэрэг нь тухайн хичээлд хандах хандлагад нөлөөлөх хүчин зүйл болж байна гэсэн дүгнэлт хийжээ. Мөн Mao Rongjian (2003) өсвөр насны сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг судалж, тэрээр хүмүүсийн хандлага, зан үйлийн харилцаанд шинжилгээ хийж, үнэлэх, төлөвлөх, гүйцэтгэх зан үйлийн алхамчилсан 9 загварыг боловсруулж туршсан байна. Fu.Dong(2014) оюутны түүвэр дээр биеийн тамирын хичээлд хандах хандлагыг судалж, оюутнуудын тухайн хичээлд хандах хандлага эерэг боловч хандлагыг илэрхийлэгч гол үзүүлэлт болох танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, зан үйлийн чадварууд нь тэнцвэртэй биш харилцан адилгүй хөгжиж байна гэсэн дүгнэлт хийжээ. Анги курс өгсөх тутам биеийн тамирын хичээлд хандах хандлага буурч байна гэсэн дүгнэлтийг зарим судлаачид хийж байгаа нь судлаачдын анхаарал татаж байна. Судлагдсан байдлын тоймоос харахад бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагын судалгаа хомс байгааг харж болохоор байна. Бодит байдал дээр биеийн тамирын хичээлийн одоогийн сургалтын арга зүй болон агуулга нь бага ангийн сурагчдын сонирхол татахуйц биш нэгэн хэвийн байдлаар явагдсанаас Сөнид баруун хошууны

бага сургуулийн сурагчдын биеийн тамираар хичээллэх урам зориг, дур сонирхлыг хөхүүлэн дэмжих нөлөө үзүүлж чадахгүй байна. Тийм учраас тус хошууны монгол бага сургуулийн бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлага, сайжруулах арга замын талаар судлан шинжлэх зорилт тавин ажилласан билээ. Сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг судлах нь биеийн тамрын хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, сургалтын орчин нөхцлийг сайруулах менежментийг хэрэгжүүлэх, сургалтын агуулга, арга зүйгээ боловсронгуй болгож сайжруулахад үндэслэл болох төдийгүй цаашид энэ чиглэлийн судлагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

“Хандлага”(attitude) хэмээх судлагдахуун нь сэтгэл судлал, нийгэм, гүн ухаан зэрэг олон салбар шинжлэх ухааны зааг дээр судлагдаж ирсэн завсар дундын ухагдахуун юм. Иймээс судаачид өөрийн өөрийн өнцөг, байр сууринаас тайлбарлаж, судалж иржээ. Хүний аливаа эд юмс, үйл явдалд хандаж буй дотоод мэдрэмж, үзэл бодол, итгэл үнэмшил, зан үйлийн гадаад илрэлийг хандлага гэж тодорхойлох чиг хандлага сэтгэл судлаачдын дунд нийтлэг ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл хандлага нь тодорхой нэг объектод чиглэж, таалагдсан эсвэл таалагдаагүй байдлыг илэрхийлдэг, танин мэдэхүй, итгэл үнэмшил дээр суурилсан хувь хүний үнэлгээ бөгөөд аливаа үйлийг дэмжих, гүйцэтгэх, дагах, зайлсхийх, эсэргүүцэх зэрэг зан үйлээр илэрдэг. Сэтгэл судлалын Оксфордын тайлбар тольд (2006) “Ямар нэгэн үзэл бодлын чиглэл, үзэл санаа, үйл явдал, хүрээлэн байгаа юмсыг үнэлэх эерэг ба сөрөг үнэлгээ, энэ бүхэн сэтгэл хөдлөл, танин мэдэхүйн мэдлэг тушлага, зан үйлийн хариу үйлдлээр тодорхойлогдоно” гэсэн байна. Сэтгэл судлаачид тухайлбал, (Rosenberg Novland 1960), (Breckler 1984), (Zanna & Rempel 1988) нар хувь хүн, өмнөх мэдлэг туршлагадаа үндэслэн эргэн тойрны эд юмсад харьцангуй тогтвортой хандах сэтгэцийн төлөв байдал гэж тодорхойлжээ. Хүмүүсийн аливаад хандах хандага нь танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл гэсэн нэгдмэл ойлголтыг агуулдаг. Хандлага нь хүний хэрэгцээ сонирхол, итгэл үнэмшлээс үүдэлтэй бөгөөд мэдлэгийг танин мэдэж олж авах замаар энэ тал хөгжиж төлөвшиж байдаг. Хүн хийх, гүйцэтгэх, эзэмших үйлийн талаар хэдийчинээ тодорхой мэдлэг туршлагыг эзэмшинэ төдий хэмжээгээр түүнийг үйлдэх хүсэл сонирхол сэдэл тэмүүлэлтэй болно гэсэн хэрэг. Хандлагын сэтгэл хөдлөлийн тал нь хийж, суралцаж байгаа зүйл таалагдах, таалагдахгүй байдлыг илэрхийлж байдаг. Хүн аливаа зүйлийг хийхдээ урам зоригтой, сэтгэл дүүрэн, баяр бахдалтай байвал илүү үр

дүнтэй, тууштай, чин сэтгэлээ зориулан өөрийгөө дайчлах сэтгэл зүйн бэлтгэл бий болдог. Хандлага бол мөн хүний зан үйлийн хариу үйлдлийг илэрхийлэдэг. Тухайн хичээл дээр зааж байгаа дасгал хөдөлгөөний техникүүдийг эзэмшиж байгаа байдал, гүйцэтгэлийн үр дүнгээр хандлагын зан үйлийн тал нь тодорхойлогдох юм. Эдгээр ойлголт, судлаачдын онолын үзэл баримтлалыг нэгтгэн дүгнэж үзвэл хандага нь удаан хугацааны явцад хөгжин төлөвшдөг, тогтвортой илэрдэг, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл гэсэн бүрэлдэхүүнтэй цогц нэгдмэл ойлголт болох нь харагдаж байна. Хандлагын талаарх онолын үзэл санааг энэхүү судалгааны ажлын онол арга зүйн үндэс болгон ашиглаж судалгааг явуулсан болно.

Судалгааны арга зүй

БНХАУ-ын ӨМӨЗО -ны Шилийн гол аймгийн Сөнид баруун хошууны монгол бага сургуулийн 972 сурагчдаас сурвалж бичиг, анкет, онолын логик задлан шинжлэл, ярилцлагын аргыг тус тус ашиглан судалгаа авч, судалгааны үр дүнд математик болон чанарын боловсруулалт шинжилгээ дүгнэлт хийсэн болно. Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг танин мэдэхүй, зан үйл, сэтгэл хөдлөл гэсэн 3 хүрээнд авч үзэж, Р. Лайкертын үнэлгээний хэмжүүрийн аргыг ашиглан шалгуур тус бүрийг 6 дэд үзүүлэлтийн дагуу боловсруулсан асуултын тусламжтайгаар хэмжээсжүүлэн үнэлгээ хийсэн. Тухайн судалгаа Ковидийн тархалтын үеийн цаг хугацаатай давхцан явагдсан учраас Монгол улсын бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагын харьцуулсан судалгаа хийх боломж бүрдээгүй. Цаашид энэхүү судалгааны үр дүн дүн судлаачийн хийж байгаа дүгнэлтэд анхаарал хандуулж, Монгол сурагчдын түүвэр дээр судалгааг үргэжлүүлж, үнэлгээ дүгнэлт хийх шаалдагатай хэмээн үзэж байна.

Сөнид баруун хошууны монгол бага сургуулийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг судалсан судалгааны үр дүнгээс


Тухайн судалгаанд ӨМӨЗО -ны Шилийн гол аймгийн Сөнид баруун хошууны монгол бага сургуулийн 972 сурагчид оролцсон. Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл гэсэн 3 бүрэлдэхүүн хүрээнд судлан шинжилгээ дүгнэлт хийсэн болно. Биеийн тамирын хичээлд хандах хандлагын танин мэдэхүй талыг илэрхийлэх шалгуур үзүүлэлтэд бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлийн ач холбогдлын талаарх ойлголт, мэдлэгийн ерөнхий баримжааг авч үзсэн бөгөөд дараах асуултаар судалж тодорхойлохыг зорьсон болно. Биеийн тамирын хичээлийн талаар ойлголт төсөөллийг судалгаанд оролцсон сурагчдын хариултаас харахад дараах онцлог илэрч байна.

Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлийн талаарх мэдлэг ойлголтын тоон үзүүлэлт

Үзүүлэлт	1	2	3	4	5	6
Хандлагын танин мэдэхүйн талын асуултын хэмжүүр	Биеийн тамирын хичээлээр бие махбодоо чийрэгжүүлнэ.	Биеийн тамирын хичээлийн ололт маш их	Багшийн ярьсан хичээлийн агуулгийг маш сайн ойлгодог	Хичээл дээр тоглох цаг маш бага	Миний хувьд хичээлийн агуулга ойлгомжгүй	Хичээлийн агуулгыг маш сайн ойлгомжтой заадаг.
Маш ханамжтай	660 68%	234 24%	609 63%	524 54%	30 3%	310 32%
Ханамжгүй	182 18%	338 35%	252 26%	147 15%	300 31%	433 45%
Мэдэхгүй	92 9%	362 37%	34 3%	194 20%	10 1%	102 10%
Ханамжгүй	26 4%	26 3%	60 6%	42 4%	312 32%	113 12%
Тун ханамжгүй	12 1%	12 1%	17 2%	65 7%	320 33%	14 1%

Зураг 1

Сурагчдын биеийн тамирын хичээлийн талаарх мэдлэг ойлголт



Судалгаанд оролцсон сурагчдын 86 хувь нь биеийн тамирын хичээл нь бие махбодыг чийрэгжүүлэх, эрүүл байх нэг хүчин зүйл гэж ач холбодлыг ойлгож, үзэж байна. 89 хувь нь багшийн ярьсан хичээлийн агуулгыг маш сайн ойлгодог. 77 хувь нь биеийн тамирын хичээлийн агуулгыг маш сайн ойлгомжтой заадаг гэж үзжээ. Энэ нь сургуулийн биеийн тамирын хичээлийн агуулга нь сурагчдад ойлгоход хялбар байдлаар төлөвлөн явуулж байгааг харуулж байна. Судалгаанд оролцсон сурагчдын 34 хувь нь биеийн тамирын хичээлийн агуулга ойлгомжгүй гэж хариулсан нь хичээлийн агуулгыг эргэн үзэж, илүү сонирхолтой, ойлгоход хялбар байлгах тал дээр анхаарах шаадлагатай байгааг харуулж байна.


Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг илэрхийлэх нэг үзүүлэлт болох сэтгэл хөдлөлийн талыг илэрхийлэх шалгуурын хүрээнд судалгааны үр дүнг боловсруулахад дараах үр дүнг гарсан болно. Энэ шалгуур үзүүлэлт нь сурагчдын биеийн тамирын хичээлд оролцох явцдаа авч байгаа урам зориг, сэтгэл ханамж, цашид тухайн хичээлд оролцох хүсэл сонирхлыг илрүүлэх зорилготой.

Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагын сэтгэл хөдлөлийн талын тоон үзүүлэлт

Үзүүлэлт	1	2	3	4	5	6
Хандлагын сэтгэл хөдлөлийн асуултын хэмжүүр	Биеийн тамирын хичээл надад баяр баясал төрүүлдэг.	Биеийн тамирын хичээлдээ сэтгэл ханамжтай байдаг	Хичээлийн цагийг нэмэгдүүлэхийг хүсэж байна	Багш намайг анхаарч санаа тавьж, халамжилд аггүй	Миний спортын ур чадвар дээшилсэн	Хичээлийн агуулга, хэлбэр нь маш их таалагддаг.
Маш ханамжтай	274 29%	237 24%	730 76%	118 12%	262 27%	180 18%
Ханамжтай	398 41%	377 39%	186 19%	97 10%	195 20%	240 25%
Мэдэхгүй	160 16%	114 12%	10 1%	533 55%	171 18%	318 33%
Ханамжгүй	100 10%	176 18%	22 2%	46 5%	270 28%	166 17%
Тун ханамжгүй	40 4%	68 7%	24 2%	178 18%	74 7%	68 7%

Зураг 2

Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагын сэтгэл хөдлөлийн үзүүлэлт



Судалгаанд оролцсон сурагчдын 95 хувь нь биеийн тамирын хичээлийг нэмж оруулахыг хүсжээ. Энэ нь сурагчдын биеийн тамираар хичээллэх урам зориг, хүсэл эрмэлзэл харьцангуй өндөр байгааг харуулж байна. Сурагчдын 70 хувь нь биеийн тамирын хичээл нь баяр хөөр, урам зориг төрүүлдэг, сэтгэл хангалуун оролцдог гэж хариулсан байна. Сурагчдын 63 хувь нь биеийн тамирын хичээлдээ сэтгэл ханамжтай байдаг гэж хариулжээ. Судалгаанд оролцсон сурагчдын 25 хувь нь биеийн тамирын хичээлд тийм ч сэтгэл ханамжтай биш, 24 хувь нь хичээл зааж байгаа арга хэлбэр, агуулга нь таалагдахгүй, сонирхолгүй байгааг илэрхийлжээ. Үүнээс гадна, сурагчдын 55 хувь нь хичээл дээр багш өөрийг нь анхаарч байгаа эсэхийг мэдэхгүй гэж хариулсан байна. Энэ нь биеийн тамирын багш нар хичээл дээрээ сурагчдын хүсэл хэрэгцээг ойлгож сонсох, дэмжин туслах тал дээр бага анхаарч ирснийг судалгааны үр дүн харуулав. Иймэрхүү хайхрамжгүй харьцаа хандлага нь биеийн тамираар

хичээллэн суралцах явцдаа урам зориг, сэтгэлийн таашаал авахаас илүүтэйгээр албадалгын шинжтэй суралцах, урам зориг сэтгэл хөдлөлд сөргөөр нөлөөлөлж болохыг цаашид анхааран үзэж, сургалт, харилцааны арга барилаа илүү сайжруулах хэрэгтэй болохыг судалгааны үр дүн харуулж байна.

Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагыг илэрхийлэх бас нэг үзүүлэлт болох зан үйлийн талыг илэрхийлэх шалгуурын хүрээнд судалгааны үр дүнг боловсруулахад дараах үр дүн гарсан болно. Энэ шалгуур үзүүлэлт нь сурагчдын хичээлд оролцох идэвх оролцоо, зүтгэл чармайлтыг илэрхийлдэг.


Хүснэгт 3

Биеийн тамирын хичээлд хандах хандлагын зан үйлийн тоон үзүүлэлт

Үзүүлэлт	1	2	3	4	5	6
Хандлагын зан үйлийн асуултын хэмжүүр	Биеийн тамирын хичээл ороход хамгийн түрүүнд жагсдаг	Биеийн тамирын хичээлдээ маш идэвхтэй оролцдог	Биеийн тамирын хичээл ороход маш ихээр баярладаг	Хичээлдээ маш анхааралтай ханддаг	Хичээл дээр заасан хөдөлгөөн бүрийг хичээнгүйлэн сурдаг	Шалгалт авна гэж сонсмогц хичээлд орох сонирхолгүй болдог.
Маш ханамжтай	157 16%	335 34%	94 10%	143 15%	370 38%	232 24%
Ханамжтай	300 31%	380 40%	140 14%	354 37%	404 42%	410 42%
Мэдэхгүй	118 12%	139 14%	213 22%	312 32%	42 4%	60 6%
Ханамжгүй	220 23%	69 7%	222 23%	100 10%	102 10%	192 20%
Тун ханамжгүй	177 18%	49 5%	303 31%	63 6%	54 6%	78 8%

Зураг 3

Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд хандах хандлагын зан үйлийн үзүүлэлт



Судалгаанд оролцсон сурагчдын 80 хувь нь биеийн тамирын хичээл дээр янз бүрийн дасгал хөдөлгөөн хийхэд маш идэвхтэй оролцдог, 74 хувь нь биеийн тамирын хичээлийн хөдөлгөөнийг сайн хийхээр чармайж, зүтгэл гаргадаг гэсэн байна. Энэ нь сурагчдын биеийн тамирын хичээлд суралцах идэвх зүтгэл маш сайн байж, өөрийн давуу талаа илрүүлж, харуулахыг хүсэж байгааг харуулж байна. Биеийн тамирын хичээл эхлэх хонх дуугарахаас өмнө сурагчдын 47 хувь нь хичээлд бэлтгэж эгнэн

зогсдог, 54%-хувь нь тамирын хичээл орно гэдгийг мэдсэн боловч хичээлд оролцох идэвх чармайлт хангалтгүй гэсэн хариулт өгсөн байна. Сурагчдын биеийн тамирын хичээлд идэвхгүй оролцож байгаагийн шалтгааныг ярилцлагын аргаар тодруулахад тухайн хичээл нь ямар ч шинэ содон зүйлгүй, сургалтын тоног төхөөрөмжийн хоцрогдож, хуучирсан хэрэгсэлүүд нь сурагчдын суралцах урам сонирхлыг өдөөж, хөгжөөж чадахгүй байна гэж үзэж байна. Үүнээс гадна сурагчдын 66% нь биеийн тамирын шалгалт авна гэж хэлэхэд биеийн тамирын хичээлд оролцох дургүй болдог гэсэн байна. Биеийн тамирын хичээлийн шалгалт нь шалгалтаас айх айдас төрүүлж, сурагчдад сэтгэл зүйн дарамтыг бий болгож байна. Дээрх судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

ДҮГНЭЛТ

1. Судалгаанд оролцсон нийт сурагчдын 86 хувь нь биеийн тамирын хичээл нь бие махбодыг чийрэгжүүлэх, эрүүл байх нэг хүчин зүйл гэж үзэж байхад 69 хувь нь биеийн тамирын хичээл дээр чөлөөтэй тоглох цаг бага, 34 хувь нь биеийн тамирын хичээлийн агуулга ойлгомжгүй гэж хариулсан нь тухайн хичээлийн агуулга, арга зүйг эргэн үзэж, илүү сонирхолтой, тухайн насны хүүхдийн онцлогийг харгалзан үзэх тал дээр анхааран ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.
2. Судалгаанд оролцсон сурагчдын 95 хувь нь биеийн тамирын хичээлийн цагийг нэмж оруулахыг хүсэж байгаа нь биеийн тамираар хичээллэх урам зориг, хүсэл эрмэлзэл өндөр байгааг харуулж байна. Сурагчдын 55 хувь нь хичээл дээр багш өөрийг нь анхаарч байгаа эсэхийг мэдэхгүй гэж хариулсан байна. Энэ нь багш нар, хичээл дээрээ сурагчдын урам зориг, хүсэл хэрэгцээг ойлгож сонсох, дэмжих, ойр дотно харилцах тал дээр бага анхаарч ирснийг судалгааны үр дүн харуулав. Иймэрхүү харьцаа хандлага нь албадалгын шинжтэй урамгүй суралцах, тэдний сэтгэл хөдлөлд сөргөөр нөлөөлөлж болохыг анхааран үзэж, сургалт, харилцааны одоогийн арга барилаа илүү сайжруулах хэрэгтэй болохыг судалгааны үр дүн харуулж байна.
3. Судалгаанд орлцсон сурагчдын 80 хувь нь биеийн тамирын хичээл дээр янз бүрийн дасгал хөдөлгөөн хийхэд маш идэвхтэй оролцдог, 54%-хувь нь хичээлд оролцох идэвх сул гэж хариулсан байна. Тухайн хичээл нь ямар ч шинэ содон зүйлгүй, сургалтын тоног төхөөрөмжийн хоцрогдож, хуучирсан хэрэгсэлүүд нь сурагчдын биеийн тамираар хичээллэх урам сонирхлыг өдөөж, хөгжөөж чадахгүй байна гэж үзэж байна. Биеийн тамирын хичээлийн шалгалт нь шалгалтаас айх айдас төрүүлж, сурагчдад сэтгэл зүйн дарамтыг бий болгож байна.

4. Цаашид энэхүү судалгааны үр дүнд дүгнэлт хийж, бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлд оролцох оролцоо, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, түүний ач холбогдлыг ойлгуулах, итгэл үнэмшилд нөлөөлөх, идэвх сонирхлыг дэмжих сургалтын агуулга, арга зүйг шинэчлэн боловсруулах, тухайн хичээлийн бодлого төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

- [1]. Нүү юй бүве(2014) “ Бага сургуулийн сурагчдын бие махбодын хэв чанар муудаж байгаа асуудал ” “Дундад улсын сургуулийн гаднах сурган хүмүүжил” 2014 , 01 ., 196
- [2]. Зан чюй (2013) , “Бээжин хотын баруун хот тойргийн бага сургуулийн биеийн тамирын хичээлийг өрнүүлж байгаа одоогийн байдал хийгээд задлалт ” [D].Бээжингийн биеийн тамирын их сургууль
- [3]. Лиу ен шен (2013) Наран гэрэлт биеийн тамирын ахуй байдал доор Жанаан хотын бага сургуулийн сурагчдын биеийн тамирын хичээлийн дур сонирхлын одоогийн байдлын үнэлгээ хийгээд хэрэгжүүлэхбодлого. Шиндон их сургууль
- [4]. Багшийн нэвтэрхий толь. (1987) [M].Бээжин нийгмийн шинжлэх ухааны тулгуур бичгийн нийгэмлэг , 351 .
- [5]. Цэвэл Я. (1966) Монгол хэлний тайлбар толь
- [6]. Canan&Hulya(2005) Puplis Attitudes, and Motivation for physical education- Some Psychological Aspects of Physical Education, Adolescence,158(40);375-385
- [7]. Мао Rongjian (2003) Өсвөр насны сурагчдын дасгал хөдөлгөөнд хандах хандлага., Бээжингийн спортын их сургууль
- [8]. Oxford dictionary of psychology (2006)63-64 pp
- [9]. Doob L.W The behavior attitudes Psychological Review,1947, 135-156
- [10]. Zanna &Rempel(1988) models Of Attitude-behavior relations/ Psychological Review. 1988;6;452-464